“ЭФ БИ ЭЛ ЖИ” ХХК

# ГОВЬСҮМБЭР АЙМАГ, СҮМБЭР СУМ, 1-Р БАГ ЧОЙР ӨРТӨӨНД БАЙРЛАХ “ЭФ БИ ЭЛ ЖИ” ХХК-ИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/РЕГИСТРИЙН ДУГААР: 5282063/

ГОВЬСҮМБЭР АЙМАГ

2024 ОН

## АГУУЛГА

НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ..... 3

*ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 5*

*ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 13*

*ДӨРӨВ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 17*

*ТАВ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 18*

*ЗУРГАА. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ ..... 22*

*ДОЛОО. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 24*

*НАЙМ . ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 29*

*ДҮГНЭЛТ ..... 30*

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 2. Ажлын хувцас олгосон байдал ........ 8
Зураг 3.Агаарын бохирдлын төлбөр төлсөн байдал ........ 9
Зураг 4. Унданд хэрэглэж буй цэвэршүүлсэн баллонтой ус ........ 9
Зураг 5. Засварын газрын урд хэсгийг цементлэж хатуу хучилт хийсэн байдал ........ 11
Зураг 6. Ачиж, буулгах хэсэг хатуу хучилттай байдал ........ 12
Зураг 7. Хайлаас мод тарьж, ургуулсан байдал ........ 12
Зураг 8. Оффисын урд хэсгийн ногоон байгууламж ........ 14
Зураг 9. Цэцгийн мандал байгуулсан байдал ........ 14
Зураг 10. Тогтоосон цэгт мод тарьж буй байдал ........ 15
Зураг 11. Мод тарьсан талбайн байршлын зураг ........ 15
Зураг 12. Хашаалж мод тарьсан талбай ........ 16
Зураг 13. Их цэвэрлэгээ зохион байгуулсан байдал ........ 19
Зураг 14. Хог хаягдлын төлбөр төлсөн баримт ........ 19
Зураг 15. Хогийн цэгийг хатуу хучилттай болгосон байдал ........ 20
Зураг 16. Ангилан ялгах боломжтой хогийн сав ........ 20
Зураг 17. Жонш савладаг шуудай ........ 21
Зураг 18. Бохирын цооногийг цементлэсэн байдал ........ 21
Зураг 19. Хөрсний дээж авч буй байдал, хөрсний шинжилгээний хариу ........ 23
Зураг 22. Газрын төлбөр төлсөн баримт ........ 26
Зураг 23. БОННҮ-ий тайлангийн нүүр ........ 27
Зураг 24. Шийтгэлийн хуудас ........ 27
Зураг 25. Ажилчдад сургалт зохион байгуулж буй байдал ........ 28
Зураг 26. Осол аюулаас урьдчилан сэргийлэх самбар, тэмдэгүүд ........ 28

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ........ 5
Хүснэгт 2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт ........ 13
Хүснэгт 3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ........ 17
Хүснэгт 4. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт ........ 18
Хүснэгт 5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт ........ 22
Хүснэгт 6. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт ........ 24
Хүснэгт 7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөөний биелэлт ........ 29
Хүснэгт 8. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын гүйцэтгэл ........ 30

# НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Эф Би Эл Жи” ХХК-ийн Гаалийн хяналтын бүс төсөл нь Сүмбэр сумын нутаг дахь төмөр замын Чойр өртөөнд байрлана. Аймгийн төв Чойр хот нь Монгол улсын төвийн бүсийн зүүн өмнөд хэсэгт Улаанбаатар хотоос зүүн урагш 250 км зайд оршино.

Тус гаалийн хяналтын бүс нь Говьсүмбэр аймгийн төвд байрлах тул бүх үйлчилгээндээ ойр, дэд бүтэц сайн хөгжсөн. Цахилгаан эрчим хүчийг төвийн эрчим хүчний системээс хангадаг, зам харилцааны хувьд Улаанбаатар-Чойр-Замын-Үүд чиглэлийн хатуу хучилттай замаар холбогдсон.

Гаалийн хяналтын бүс нь Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 1-р баг, Үйлдвэрлэлийн 115 тоотод орших ба нийт 2.3 га талбайг хамардаг бөгөөд Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2018 оны 11 сарын 23-ны өдрийн А/371 тоот захирамжаар үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар зориулалтаар 23317.0$м^2$ газрыг 6 жилийн хугацаатай эзэмших эрхээр авсан байна.

Гаалийн хяналтын бүс нь нийт 2.3 га талбайтай бөгөөд 10.0 мян.тн ачаа хадгалах хүчин чадалтай. “Чойр өртөөн дэх гаалийн хяналтын бүс” нь орон нутагт үйл ажиллагаа/төрийн болон хувийн бизнес эрхэлж/ явуулж байгаа иргэд, аж ахуйн нэгжүүдэд төрийн байгууллагын үйл ажиллагааг тэр дундаа гаалийн байгууллагын үйл ажиллагааг хүртээмжтэй чанартай, түргэн, шуурхай, тасралтгүй хүргэх зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулдаг.

Гаалийн хяналтын бүс нь захиргаа, аж ахуйн хэсэг болон технологийн хэсгээс бүрдэх ба захирал, менежер, механик, 3 оператор, 3 харуул, үйлчлэгч нийт 11 ажилчинтай үйл ажиллагаа явуулж байна.

Гаалийн хяналтын талбайн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаал “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын хамт тайлагнасан болно.

Чойр өртөөн дэх Гаалийн хяналтын бүс нь тайлант онд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.

- Төслийн үйл ажиллагаанаас гарч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад шаардагдах зардлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд жил бүр тусган хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар хийсэн ажлыг холбогдох газруудад тайлагнаж байна.
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээнүүдийг тайлант онд авч хэрэгжүүлсэн.
- Говьсүмбэр аймгийн ЗДТГ, аймгийн БОАЖГ, БОАЖЯ болон засаг захиргааны байгууллагуудтай харилцаа холбоотой ажиллаж байгаль хамгаалах арга хэмжээнүүдийг авч ажилласнаар байгаль орчинд болон, ажилчдын эрүүл мэндэд ямар нэгэн сөрөг нөлөөлөл үзүүлээгүй болно.
- Гаалийн хяналтын бүсийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайланг батлуулсан.
- Байгаль орчны төлөв байдал, газрын чанарын хянан баталгааны тайланг хийлгэж баталгаажуулсан.
- Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгэсэн.
- Галын хор, багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг үе шаттай шалган, хэвийн түвшинд байлгаж ажилласан.
- Жил бүр оффисын барилгын урд цэцгийн мандал байгуулж, өмнөх жилүүдэд тарьсан моддыг арчилж тордсон ба ургалт сайн байна.
- Сүмбэр сумын ЗДТГ-аас тогтоосон газарт мод тарьсан.

## ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**Хүснэгт 1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

| № | Байгаль орчны бүрдэл хэсгүүд | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал, мян.төг | Тоо хэмжээ | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1. | Агаар орчин | Гаалийн хяналтын талбайд бараа буулгах, ачих үед тоосжилт, дуу чимээ, хорт хий ялгарах | "Эф Би Эл Жи" ХХК нь гадна агаарын шинжилгээг хийлгэхээр ЦУОШГ-ын Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн итгэмжлэгдсэн лабораторитой холбогдон агаарын шинжилгээг хийлгэхээр тохирсон боловч хугацаандаа амжиж хэмжилт хийж чадаагүй бөгөөд 10 сарын сүүлээр ирж хэмжилт хийлгэхээр тогтсон. | Ачиж, буулгах хэсэг | Удаа | | | | 2024 онд | Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага MNS4585:2016 |
| 2. | | | 2024 онд нийт ажилчдад ажлын хувцас олгосон. | Ажилчдад | Удаа | | 1500.0 | | 2024 онд | Дуу, шуугиан. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага. MNS 5002: 2000 Хамгаалалтын хувцас ерөнхий шаардлага. MNS (ISO) 13994: 2003 |
| 3. | | | Автомашины түлш шатахууны дутуу шаталтаас агаарт үүсэх хорт хийн ялгаралтыг багасгах, бууруулах зорилгоор автомашины | Төслийн талбайд | Тогтмол | | 500.0 | | 2024 онд | Тоос. Ажлын байрны агаар дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага. MNS 5010-2001 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | агаарын бохирдлын төлбөрийг төлсөн. Мөн Гаалийн хяналтын талбайн үйл ажилагаанд ашиглаж буй машин техникийг засвар үйлчилгээг өөрийн засварын газарт хийж тос, маслыг сольсон. | | | | | |
| **4.** | Усны нөөц, чанар | Эрүүл ахуйн шаардлага хангасан усыг ундaнд хэрэглэх | Ажилчдын ундны усанд цэвэр, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн цэвэршүүлсэн шүүлтүүртэй ус авч ашигласан. | Ажилчдад | - | 4080.0 | 2024 онд | Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавигдах хяналт. MNS 0900:2018 |
| **5.** | Хөрсөн бүрхэвч | Хог хаягдал болон бохирдуулагч шингэн алдагдсанаас хөрс бохирдох, олон салаа зам үүсэхээс сэргийлэх | Ахуйн хаягдлыг ил задгай хаяхгүй байх, хаягдлыг гэрээт байгууллагаар зөвшөөрөгдсөн цэгт тээвэрлүүлж ажилласан. Тайлант хугацаанд , оффисын гадна талд 3 төрлөөр ангилан ялгах боломжтой хогийн сав шинээр хийж байрлуулсан. | Оффист | | 840.0 | 2024 онд | Ариун цэврийн тухай хууль, Хог хаягдлын тухай хууль |
| **6.** | | | Тос тосолгооны материалын хаягдлаар хөрс бохирдуулахаас урьдчилан сэргийлж засварын газрын урд хэсэг, засвар үйлчилгээ хийх цэгийг цементлэж, хатуу хучилттай болгосон. | Засварын газар | - | 10106.0 | 2024 онд | Хог хаягдлын тухай хууль, Байгаль орчны хамгаалах тухай хууль |
| **7.** | Биологийн олон янз байдал | Ургамлан нөмрөг нь хүн, техникийн нөлөөгөөр устах, хог хаягдлыг ил задгай хаяснаар мал амьтад | Эзэмшил тайлбайг цементлэсэн учир шинээр ургамалжуулах талбай байхгүй. Харин оффисын урд хэсэгт байрлах ногоон байгууламжинд хайлаас мод нэмж тарин амжилттай ургуулсан. | Оффисын ногоон байгууламж орчимд | - | 1050.0 | 2024 онд | Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль<br>Хог хаягдлын тухай хууль |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хордож болзошгүй. | | | | | | | |
| **Төслийн байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал, мян.төг** | | | | | | | **18076.0** | | |

“Эф Би Эл Жи” ХХК нь гадна агаарын шинжилгээг хийлгэхээр ЦУОШГ-ын Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн итгэмжлэгдсэн лабораторитой холбогдон агаарын шинжилгээг хийлгэхээр тохирсон боловч хугацаандаа амжиж хэмжилт хийж чадаагүй бөгөөд 10 сарын сүүлээр ирж хэмжилт хийлгэхээр тогтсон.

2024 онд нийт ажилчдад өвлийн өмд, хүрэм, гутал болон зуны хантааз, өмд, гутал зэрэг ажлын хувцас хэрэгсэл зэргийг олгосон.



**Зураг 1. Ажлын хувцас олгосон байдал**

Автомашины түлш шатахууны дутуу шаталтаас агаарт үүсэх хорт хийн ялгаралтыг багасгах, бууруулах зорилгоор автомашины агаарын бохирдлын төлбөрийг төлсөн.

Мөн Гаалийн хяналтын талбайн үйл ажилагаанд ашиглаж буй машин техникийг засвар үйлчилгээг өөрийн засварын газарт хийж тос, маслыг сольсон.

МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ № - 1240308180968

| | |
|---|---|
| ТТД / Регистр: | 39001189435 / 5282063 |
| Татвар төлөгчийн нэр: | Эф Би Эл Жи |
| Татварын төрөл: | 01030717 - Автын агаарын бохирдлын төлбөр |
| Харьяалах татварын алба: | Баянзүрх / Дүүргийн төвлөрсөн |
| Төлсөн дүн: | 9,500.00 ₮ |
| Гүйлгээний огноо: | 2024-04-10 11:47:29.0 |
| Гүйлгээний утга: | 1240308180968;;5282063;;;99111150;3655103436;ЭФ БИ ЭЛ Ж;Golomtbank-Online;99111150 |
| Татварын данс: | ТЕГ.Автын АБТ - 100900000414 |
| Төлөлтийн хэлбэр: | Голомт банк |

**Зураг 2.Агаарын бохирдлын төлбөр төлсөн байдал**

Ажилчдын ундны усанд цэвэр, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн цэвэршүүлсэн шүүлтүүртэй усыг “Гүн шанд” ХХК-аас худалдан авч ашигласан.



**Зураг 3. Ундаанд хэрэглэж буй цэвэршүүлсэн баллонтой ус**

Ахуйн хаягдлыг ил задгай хаяхгүй байх, хаягдлыг гэрээт байгууллагаар зөвшөөрөгдсөн цэгт тээвэрлүүлж ажилласан. Тайлант хугацаанд , оффисын гадна талд 3 төрлөөр ангилан ялгах боломжтой хогийн сав шинээр хийж байрлуулсан.







Тос тосолгооны материалын хаягдлаар хөрс бохирдуулах, байгаль орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор засварын газрын урд хэсгийг цементлэж, хатуу хучилттай болгосон.



**Зураг 4. Засварын газрын урд хэсгийг цементлэж хатуу хучилт хийсэн байдал**

Гаалийн хяналтын талбайн 80 орчим хувь буюу ачиж, буулгах хэсгийг хатуу хучилттай болгосон тул эзэмшил газарт шинээр ургамалжуулах талбай байхгүй.

Харин оффисын урд талын ногоон байгууламжид нэмж хайлаас мод тарьж ургуулсан.



**Зураг 5. Ачиж, буулгах хэсэг хатуу хучилттай байдал**



**Зураг 6. Хайлаас мод тарьж, ургуулсан байдал**

## ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 2. **Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт**

| № | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Арга хэмжээний цар хэмжээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, мян.төг | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1. | Оффис орчмын ногоон байгууламжийн арчилгаа, тордолгоог хийнэ | Ногоон байгууламжийн арчилгаа тордолтыг хийнэ. | Ногоон байгууламж | - | - | - | 500.0 | Зуны турш | Монгол улсын Ерөнхийлөгчийн 58-р зарлиг, Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шардлага MNS 5918:2023 |
| 2. | Сүмбэр сумын ЗДТГ-аас тогтоосон газарт мод тарих ажлыг зохион байгуулна. | Сүмбэр сумын ЗДТГ-аас тогтоосон газарт мод тарина. | Нийтийн эзэмшлийн талбай | - | - | - | 5000.0 | Зуны турш | |
| **Нийт** | | | | | | | **5500.0** | | |

“Эф Би Эл Жи” ХХК-ийн нь газар эзэмших зөвшөөрөлтэй талбайн ачиж, буулгах хэсгийг бүрэн хатуу хучилттай болгосон бөгөөд оффисын урд талд талд байгуулсан ногоон байгууламжийн арчилгааг хийж нэмж хайлаас мод тарьж ургуулсан.



**Зураг 7. Оффисын урд хэсгийн ногоон байгууламж**

Мөн оффисын барилгын урд талд цэцгийн мандал байгуулж амжилттай ургуулсан.



**Зураг 8. Цэцгийн мандал байгуулсан байдал**

Тэрбум мод тарих ажил

Сүмбэр сумын ЗДТГ-ын мод тарихаар тогтоож өгсөн талбай буюу 2-р багийн нутаг, төмөр замын төв гарамын зүүн талд дахь 1 га газарт Гаалийн хяналтын талбайн ажилчид 1000ш хайлаас модыг 10 сард тарсан. Мод тарсан талбайг хашаалж хамгаалсан.



**Зураг 9. Тогтоосон цэгт мод тарьж буй байдал**




**Зураг 10. Мод тарьсан талбайн байршлын зураг**



**Зураг 11. Хашаалж мод тарьсан талбай**

## ДӨРӨВ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**Хүснэгт 3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

| № | Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв | Хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хүрээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, мян.төг | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрхзүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1 | Археологийн болон палеонтологийн дурсгал | Эзэмшил талбай нь бүхэлдээ хатуу хучилттай бөгөөд БОННҮ-ээр археологийн болон палентологийн дурсгал илрээгүй болно. | Археологийн дурсгал илрээгүй тул түүх, соёлын өвийг хамгаалах ажил хийгдээгүй болно. | - | - | - | Төсөл хэрэгжих хугацаанд | Соёлын өвийг хамгаалах тухай хууль<br>Газрын тухай хууль |
| **Нийт зардал** | | | | | | - | | |

“Эф Би Эл Жи” ХХК-ийн эзэмшил талбайн ихэнх хэсэг хатуу хучилттай бөгөөд БОННҮ-ээр археологийн болон палентологийн дурсгал илрээгүй. Иймд уг төслийн үйл ажиллагаанаас түүх соёлын өвийг хамгаалах ажил хийгдээгүй болно.

## ТАВ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**Хүснэгт 4. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт**

| № | Хог хаягдлын ангилал | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал, мян.төг | Тоо хэмжээ | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа | Баримтлах эрхзүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1. | Ахуйн хог хаягдал | Гаалийн хяналтын бүсийн ажилчид хавар, намартаа их цэвэрлэгээ зохион байгуулж ойр орчимд үүссэн хог хаягдлыг тогтмол цэвэрлэж ажилласан. Мон хог хаягдал гаргасны төлбөрийг хугацаанд нь төлж ажилласан. | Үйл ажиллагаанаас гарах хог хаягдал | - | - | - | 480.0 | 2024 он | Хог хаягдлын тухай хууль |
| 2. | | Ажилчид зориулалтын цэгээс гадагш элдэв хог хаягдал хаяхгүй, газрын төрх, хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байхад анхаарч эргэн тойрны хог хаягдлыг цэвэрлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулж ажилласан. | Үйл ажиллагааны явцад | - | - | - | - | 2024 он | |
| 3. | Дахин ашиглах | Оффисын гадна талд 3 төрлөөр ангилан ялгах боломжтой хогийн сав шинээр хийж байршуулсан. Өдөр тутмын үйл ажиллагаанаас гардаг хог хаягдлын төрлийг бууруулах зорилгоор жонш ялгахад шуудай ашигласан. | Үйл ажиллагааны явцад | - | - | - | - | 2024 он | |
| 4. | Шингэн хаягдал | Ахуйн хэрэглээнээс гарсан шингэн хаягдлыг соруулах бохирын цооног орчмыг цементлэн хатуу хучилттай болгож хөрс хамгаалах, орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан. | Бохирын цооног | - | - | - | 1000.0 | 2024 он | |
| 5. | Аюултай | 2024 онд Ажилласан тос, масло бэлтгэн нийлүүлэх тухай №2024/06 тоот гэрээг “Эко эд” ХХК-тай байгуулсан бөгөөд гэрээний хэрэгжилтийг ханган ажилласан. | Аюултай хог хаягдлын хэмжээнд | - | - | - | - | 2024 он | |
| **Нийт зардал** | | | | | | | **1480.0** | | |

Гаалийн хяналтын бүсийн ажилчид хавар, намартаа их цэвэрлэгээ зохион байгуулж ойр орчимд үүссэн хог хаягдлыг тогтмол цэвэрлэж ажилласан. Мон хог хаягдал гаргасны төлбөрийг хугацаанд нь төлж ажилласан.



**Зураг 12. Их цэвэрлэгээ зохион байгуулсан байдал**

ХААН БАНК

Огноо/Date: 2024.10.22 15:48:27

**Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information**

**Журналын/Journal No: 33337200**

**Системийн огноо/System Date:2024.10.22 15:48:06**

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Дт/From** | **Дансны/Картын дугаар Account/Card number** 5163290662 | **Нэр/Name** ЭФ БИ ЭЛ ЖИ | **Дүн/Amount** 70,000.00 MNT | **Ханш/Rate** 1.00 |
| **/ Далан мянган төгрөг /** | | | | |
| **Кт/To** | **Банкны дугаар/Branch No** 05 **Дансны/Картын дугаар Account/Card number** 5990479622 | **Банкны нэр Bank Name** Хаан банк **Нэр/Name** ТОХИЖИЛТ СҮМБЭР ОНӨААТҮГ | 70,000.00 MNT | 1.00 |

**Гүйлгээний утга/Transaction description:**
**Эф Би Эл Жи ХХК рд:5282063**

**Зураг 13. Хог хаягдлын төлбөр төлсөн баримт**

Төслийн зориулалтын цэгээс гадагш элдэв хог хаягдал хаяхгүй, газрын төрх, хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээний хүрээнд “Эф Би Эл Жи” ХХК нь гадна хогийн цэгийг шинэчлэн засварлаж, доод хэсгийг хатуу хучилт хийж хөрс бохирдохоос хамгаалсан байна.



**Зураг 14. Хогийн цэгийг хатуу хучилттай болгосон байдал**

Оффисын гадна талд 3 төрлөөр ангилан ялгах боломжтой хогийн сав шинээр хийж байршуулсан. Өдөр тутмын үйл ажиллагаанаас гардаг хог хаягдлын төрлийг бууруулах зорилгоор жонш ялгахад шуудай ашиглаж байна. Тус жоншны шуудайг дахин ашиглах боломжтой юм.




**Зураг 15. Ангилан ялгах боломжтой хогийн сав**



**Зураг 16. Жонш савладаг шуудай**

Манай компани 2024 оны үйл ажиллагаандаа Хог хаягдлын тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөн зориулалтын цэгээс өөр газарт хог хаягдал хаяхгүй байх, хог хаягдлыг ангилан ялгаж тээвэрлэгчид хүлээлгэн өгөх зэрэг арга хэмжээ авч ажилласан.

Ахуйн хэрэглээнээс гарсан шингэн хаягдлыг соруулах бохирын цооног орчмыг цементлэн хатуу хучилттай болгож хөрс хамгаалах, орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан.



**Зураг 17. Бохирын цооногийг цементлэсэн байдал**

Үйл ажиллагаанд ашигладаг техник хэрэгслийн ашигласан тосыг түр хуримтлуулан гэрээт байгууллагад нийлүүлдэг. 2024 онд Ажилласан тос, масло бэлтгэн нийлүүлэх тухай №2024/06 тоот гэрээг “Эко эд” ХХК-тай байгуулсан.

# ЗУРГАА. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

**Хүснэгт 5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт**

| № | Байгаль орчны бүрдлүүд | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналтын цэгийн байршил | Хугацаа ба давтамж | Давтамжийн тоо | Нэгжийн зардал мян.төг | Нийт зардал, мян.төг | Тайлбар | Баримтлах эрхзүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1 | Эзэмшил газрын хөрсний бохирдлыг /эрүүл ахуй, хүнд металл/ хянах | Агрохими | Хог хаягдлын цэгийг хатуу хучилттай болгосон тул барилгажаагүй сул талбайгаас хяналтын дээжийг авч агрохими, хүнд металл, эрүүл ахуйн бохирдлыг “Инженер геодези” ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн. | 2 дээж | 1 | 50.0 | 50.0 | Инженер геодези ХХК-ийн итгэмжлэгдсэн лаборатори | Ариун цэврийн тухай хууль Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 5850 : 2008 |
| 2 | | Хүнд металл, эрүүл ахуй | | | 2 | 50.0 | 100.0 | | |
| 3 | Үйл ажиллагааны үед агаарын шинжилгээ хийлгэж нийт тоос, нарийн ширхэгт тоосонцорыг хэмжүүлэх | Тоос /$PM_{10}$, $PM_{2.5}$/, $CO_2$, $SO_2$, $NO_2$ | Төслийн талбайгаас | Хагас жилд 1 удаа | - | - | - | Аймгийн УЦУОШГ-аар | Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага MNS4585:2016 |
| 4 | | | Уурын зуух орчмоос | Жилд 1 удаа | - | - | - | Аймгийн УЦУОШГ-аар | Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага MNS4585:2016 |
| | Нийт | | | | | | **150.0** | | |

“Эф Би Эл Жи” ХХК нь орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу хөрсний дээж авч “Инженер Геодези” ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторид өгч шинжлүүлэн дүгнэлт гаргуулсан.

Хөрсөнд хийсэн шинжилгээгээр хөрсний урвалын орчин: 8.76 буюу шүлтлэг шинжтэй, ялзмагийн агууламж: 1.89% буюу ядуу агууламжтай, хөрсний цахилгаан дамжуулах чанар болон давсны эзлэх хувь бага, 100 гр хөрсөн дэх хөдөлгөөнт фосфор-8.3 мг дунд хангамжтай, солилцох кали 14мг дундаж, шингээгдсэн сууриудын нийлбэр хангалттай байна. Хөрсний ерөнхий үржил шимийн төвшин дунд зэрэг байна.

Хөрсөн дэх хүнд элементийн агууламжийг өнгөн хөрснөөс авсан дээжинд 6 үндсэн элементээр тодорхойлуулсан ба Монгол улсын стандарт “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” (MNS 5850:2019)-ийн дүнг үндэслэн элемент тус бүрээр стандартын хүлцэх агууламжийн үзүүлэлттэй харьцуулалт хийсэн.





“НАРТ ШУУН КОНСАЛТИНГ” ХХК
ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан дүүрэг, 19-р хороо, УЭГ, ЗК 17024 Ш/х 10
Утас: (976)-99176123, 99231836
E-mail: nartconsulting@gmail.com

№ 24/10-04/1

Захиалагч: **“Хос нахиа” ХХК**
Дээж авсан цэг: **“FBLG” ХХК, Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум 1-р баг Чойр хот Гаалийн хяналтын талбай**
Сорьц авсан огноо: **2024 оны 09 сар 27 өдөр**
Шинжилгээ хийсэн огноо: **10 сарын 04**

1. ХӨРСНИЙ ХИМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| № | Дээж авсан гүн, см | pH | Давс, % | ЦДЧ, ds/m | Ялзмаг, % | $CaCO_3$, % | $NO_3$, мг/100г | Солилцох сууриуд, мг-экв/100 г | | Шим тэжээлийн элементүүд, мг/100г | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | $Ca^{+2}$ | $Mg^{+2}$ | $P_20_5$ | $K_20$ |
| Дээж 1 | | | | | | | | | | | |
| 1 | 0-20 | 8.76 | 0.025 | 0.062 | 1.89 | 1.44 | 0.23 | 8 | 11 | 8.3 | 14 |

2. ХӨРСНИЙ МЕХАНИК БҮРЭЛДЭХҮҮН

| № | Дээж авсан гүн, см | Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| Дээж 1 | | | | | | | | |
| 1 | 0-20 | 21.4 | 50.2 | 11.6 | 8.5 | 2.4 | 5.9 | 16,8 |

3. ХӨРСНИЙ ЭРҮҮЛ АХУЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН. 1ГР ХӨРСӨНД

| № | Дээжний дугаар | Нянгийн тоо | Гэдэсний савханцрын титр (*E.coli*) MNS 3297:2019 | | *Анаэробын (Cl.perfringens* MNS 3297:2019 | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Шинжилгээний хариу | Шинжилгээний хариу | Бохирдлын зэрэг | Шинжилгээний хариу | Бохирдлын зэрэг |
| 1 | Дээж 2 | $6.9*10^5$ | 0.01 | 2 | ≥0.1 | 1 |

1. ХӨРСНИЙ ХҮНД МЕТАЛЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| Дээж авсан газар, Газар зүйн байршил | Дээж авсан гүн, см | Cr | Pb | Cd | Zn | Cu | Ni |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | мг/кг | мг/кг | мг/кг | мг/кг | мг/кг | мг/кг |
| Дээж 1 | 0-20 | 54.5 | 25.0 | 0.0 | 44.1 | 10.5 | 10.4 |
| Зөвшөөрөгдөх дээд хэмжээ,MNS 5850:2019 | | | | | | | |
| Элсэрхэг хөрс | | 60 | 50 | 1 | 100 | 60 | 60 |
| Шаврангар хөрс | | 100 | 70 | 1.5 | 150 | 80 | 100 |
| Шаварлаг хөрс | | 150 | 100 | 3 | 300 | 100 | 150 |

**Харгалзах түвшин* * *Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарн*

*ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТУУД : (Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд* MNS3310:1991, MNS ISO10390, *хөрсний механик бүрэлдэхүүн* MNS6824:2020, *Эрүүл Ахуйн Шинжилгээний Стандарт* MNS 5367:2004, MNS6341:2012,*Хүнд металлуудыг -хаан дарсанд атом шингээлтийн спектрометрээр* MNS ISO 11466:2007*)*

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭСЭН: Х.ҮҮГАНЦЭЦЭГ, С.НЯМДАШ
ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: Г.СОЛОНГО Ph.D, Дэд профессор

2024 ОНЫ 10 САРЫН 04 1

**Зураг 18. Хөрсний дээж авч буй байдал, хөрсний шинжилгээний хариу**

“Эф Би Эл Жи” ХХК нь гадна агаарын шинжилгээг хийлгэхээр ЦУОШГ-ын Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн итгэмжлэгдсэн лабораторитой холбогдон агаарын шинжилгээг хийлгэхээр тохирсон боловч хугацаандаа амжиж хэмжилт хийж чадаагүй бөгөөд 10 сарын сүүлээр ирж хэмжилт хийлгэхээр тогтсон.

## ДОЛОО. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**Хүснэгт 6. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт**

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Урьдчилан тооцсон төсөв, мян.төг | Хэрэгжүүлэх хуваарь 2024 он | | | Хариуцсан албан тушаалтан | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сар | сар | сар | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрөл, гэрээнүүд/ газар ашиглах, ус ашиглах гэрээ, хог тээвэрлэлтийн гэрээ, ус ашиглах зөвшөөрөл г.м/-ийг цаг хугацаанд нь чанартай биелүүлж дүгнүүлэх, сунгах, холбогдох төлбөр тооцоог хийх | - | 5 | - | 10 | Захирал | Байгаль хамгаалах тухай хууль<br>Газрын төлбөрийн тухай хууль<br>Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль |
| 2. | Ажилтнуудад байгаль орчны болон ХАБЭА-н сургалт ажлын байранд нь зохион байгуулах | 500.0 | 5 | - | 10 | Захирал | Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль |
| 3. | Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон биелэлтийн тайланг 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу тогтоосон хугацаанд боловсруулж, батлуулах | - | 5 | - | 10 | Захирал | Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам, 2019 он |
| 4. | Жонш шуудайлж буй ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж хувцас, хамгаалах хэрэгслээр хангах, болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах | 500.0 | 5 | - | 10 | Захирал | Хөдөлмөрийн тухай хууль |
| 5. | Ажилчдад болзошгүй аюул ослын үед авах арга хэмжээний талаар сургалтыг зохион байгуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар мэдээ мэдээллийг тогтмол өгч, зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх | - | 5 | - | 10 | Захирал | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль |
| **Нийт зардал** | | **1000.0** | | | | | |

"Эф Би Эл Жи" ХХК нь тайлант хугацаанд Монгол улсын хууль эрхзүйн хүрээнд хийгдэх байгаль орчны тайлан, төлөвлөгөө, татвар хураамжуудыг цаг тухайд нь төлөх, хог хаягдлыг багасгах, бууруулах, ангилан хаях хэмнэх зэргээр байгууллагын хэмжээнд холбогдох арга хэмжээнүүд авч ажилласан бөгөөд удирдлага зохион байгуулалтын ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- 2024-2028 оны байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар боловсруулан БОАЖЯ-аар баталгаажуулсан батлуулсан.
- Байгаль орчны төлөвлөгөөт аудитын мэргэжлийн байгууллага "Өртөөлөн" ХХК-аар хийлгэсэн.
- Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны тайланг илгээн Говьсүмбэр аймгийн ГЗБГЗЗГ-аар дүгнэлтийг баталгаажуулсан.
- Газрын төлбөр тооцоог бүрэн төлж, газрын гэрээг дүгнүүлсэн бөгөөд 2024 оны 11 сард газрын гэрчилгээний хугацаа дуусах тул холбогдох байгууллагад сунгуулах хүсэлт хүргүүлээд байна.
- Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, тэдгээрт хяналт тавих гэрээг Говьсүмбэр аймгийн "Тохижилт сүмбэр" ОНӨААТҮГ-тай 2 жилийн хугацаатай байгуулан хэрэгжилтийг хангаж ажилласан.
- БАҮ-ний 3-р ангитай Хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээг 1 жилийн хугацаатай гэрээ байгуулсан.
- Говьсүмбэр аймгийн ЗДТГ, Говьсүмбэр аймгийн БОАЖГ болон засаг захиргааны байгууллагуудтай байнгын харилцаа холбоотой ажилласан;
- Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж байгууллагын дотоод дүрэм журам, анхааруулга, санамжийг мөрдөж ажилласан.

## МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ № - 1240112725594

| | |
|---|---|
| ТТД / Регистр: | 39001189435001 / 5282063 |
| Татвар төлөгчийн нэр: | ЭФ БИ ЭЛ ЖИ |
| Татварын төрөл: | 01030731 - Газрын төлбөр-Дэд алба |
| Харъяалах татварын алба: | Говьсүмбэр / Сүмбэр |
| Төлсөн дүн: | 136,069.00 ₮ |
| Гүйлгээний огноо: | 2024-10-15 17:47:12.0 |
| Гүйлгээний утга: | 1240112725594;;5282063;;;99111150;3655103436;ЭФ БИ ЭЛ Ж;Golomtbank-Online;99111150 |
| Татварын данс: | Гс.Сү Газрын төлбөр - 100220500943 |
| Төлөлтийн хэлбэр: | Голомт банк |

**Зураг 19. Газрын төлбөр төлсөн баримт**

2024-2028 оны байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайланг 2022 оноос мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан боловсруулж эхэлсэн бөгөөд тайлан 2024 оны 8 сард баталгаажсан.

2023 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан учраас БОАЖГ-ын БОХ-ын ахлах байцаагчаар №527190 тоот шийтгэлийн хуудсаар торгуулийн арга хэмжээ авагдсан. Харин 2024 онд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан батлагдсаны дараа 2024 онд хэрэгжүүлэх менежментийн төлөвлөгөөг боловсруулан баталгаажуулж, хэрэгжилтийг ханган ажилласан.




БАТЛАВ:
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ Г. ЭНХМӨНХ

ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Ө. МӨНХБАЯР

"ЭФ БИ ЭЛ ЖИ" ХХК-НИЙ "ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ" ТӨСӨЛ -ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН РЕГИСТРИЙН ДУГААР:
6407447

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА:
"ХОС НАХИА" ХХК Нэр: Гарын үсэг:

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:
"ЭФ БИ ЭЛ ЖИ" ХХК Нэр: Гарын үсэг:

2024 ОН

**Зураг 20. БОННҮ-ий тайлангийн нүүр**



ШИЙТГЭЛИЙН ХУУДАС (маягт 2)

№ 0527190 2218

....оны ....сарын ....өдөр ........ хот, сум

ХЯЛБАРЧИЛСАН ЖУРМААР ШИЙДВЭРЛЭХ ЗӨРЧИЛД ШИЙТГЭЛ ОНОГДУУЛАХ ТУХАЙ

........ /эрх бүхий албан тушаалтны харьяалах байгууллага, ажил, нэр, цол, зэрэг/ ........ би Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан ........ асуудлыг шалгаад ОЛСОН нь:

Холбогдогч /харьяалах улс, хуулийн этгээдийн нэр, хүний овог, нэр, регистр/паспортын дугаар, ажил, албан тушаал, хаяг/ ........-нь ........ болох нь ........ зэрэг нотлох баримтаар нотлогдон тогтоогдож, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2.3 дахь хэсэгт заасны дагуу шийдвэрлэх боломжтой байна.

Иймд холбогдогч ........ /хүн, хуулийн этгээдийн нэр/-ийн үйлдсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн ........ зүйлийн ........ -д заасан шийтгэл оногдуулах үндэслэлтэй байх тул Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.2 дугаар зүйлд заасныг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

1. Холбогдогч ........ /хүн, хуулийн этгээдийн нэр/-ийн үйлдсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн ........ /зүйл, хэсэг, заалт/-д заасны дагуу ........ /шийтгэлийн төрөл, хэмжээ/ шийтгэл оногдуулсугай.

2. Оногдуулсан шийтгэлийн ........ төгрөгийг Төрийн сангийн ........ тоот дансанд, хохирол, нөхөн төлбөрийн ........ төгрөгийг Төрийн сангийн ........ тоот дансанд, зөрчил үйлдэж олсон мөнгөн орлогыг /улсын төсөвт/ Төрийн сангийн ........ тоот дансанд тус тус шийтгэлийн хуудсыг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор бэлнээр, бэлэн бусаар сайн дураар төлж биелүүлэхийг даалгасугай.

3. Зөрчлийн тухай хуулийн 3.6 дугаар зүйлд зааснаар хүн, хуулийн этгээдийн ........ /үйл ажиллагаа, эрх/ аль болохыг зурах/-ыг ........ хугацаагаар /хязгаарлах, хүчингүй болгох/ аль болохыг зурах/ эрх хасах шийтгэл оногдуулсугай.

4. Торгуулийн шийтгэлийг хэсэгчлэн төлүүлэх ........ үндэслэл тогтоогдсон тул оногдуулсан ........ төгрөгийн торгуулийн шийтгэлийг ........ хувийг ........ хугацааны дотор, ........ хувийг ........ хугацааны дотор, ........ хувийг ........ хугацааны дотор хэсэгчлэн сайн дураараа биелүүлэхийг даалгасугай.

5. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.5 дугаар зүйлд заасны дагуу хураан авсан:

А. Зөрчил үйлдэж олсон /хөрөнгө, орлого/, /аль нь болохыг доогуур зурах/

Б. Зөрчил үйлдэхэд ашигласан /зэвсэг, хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, уналга/. /аль нь болохыг доогуур зурах/

В. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд ач холбогдолтой баримт болох /эд зүйл, баримт бичиг/ ........ /аль нь болохыг доогуур зурах/ ........ /нэр, төрөл, тоо, хэмжээ, шинж тэмдэг/-г Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.12 болон Засгийн газрын тогтоолоор баталсан "Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам"-ын дагуу ........ шийдвэрлэсүгэй.

6. Холбогдогч ........ /хүн, хуулийн этгээдийн нэр/-д Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар ........-ны өдрийн дотор ........ үүргийг нөхөн биелүүлэхийг даалгах, эсхүл үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой ........ төгрөгийн зардлыг гаргуулсугай.

7. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд тогтоосон хугацаанд шийдвэрийг биелүүлээгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэхээр эрх бүхий албан тушаалтан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.6 дугаар зүйлд заасан харьяалах шүүхэд хүсэлт гаргана.

8. Шийдвэрийг эс зөвшөөрвөл Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.6 дугаар зүйлд заасны дагуу шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ШИЙДВЭР ГАРГАСАН:

Эрх бүхий албан тушаалтан ........ /........ /
(гарын үсэг) (нэр)

ТАНИЛЦСАН:

Холбогдогч ........ /Х. ........ /
(гарын үсэг) (нэр)

....оны ....сарын ....өдөр

**Зураг 21. Шийтгэлийн хуудас**

Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газартай хамтран нийт ажилчдад болзошгүй аюул ослын үед авах арга хэмжээ болон ХАБЭА-н сургалтыг ажлын байранд зохион байгуулж дадлага сургуулилт хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар мэдээ мэдээллийг өгсөн.

Мөн жонш шуудайлж буй ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж хувцас, хамгаалах хэрэгслээр хангахаас гадна болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээллийн самбар болон тэмдэг тэмдэглэгээ шинэчлэх арга хэмжээ авч ажилласан.



**Зураг 22. Ажилчдад сургалт зохион байгуулж буй байдал**




**Зураг 23. Осол аюулаас урьдчилан сэргийлэх самбар, тэмдэгүүд**

# НАЙМ . ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**Хүснэгт 7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөөний биелэлт**

| № | БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд | Тайлагнах хэлбэр | Мэдээллийн агуулга | Зохион байгуулах хугацааны тов | Тайлагнах зардал, мян.төг | Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан | Зохион байгуулах газар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Говьсүмбэр аймгийн БОАЖГ | БОМТ-ий тайлан албан бичгээр хүргүүлэх | БОМТ-ий биелэлт | 3-р улиралд | 50.0 | Захирал | Говьсүмбэр аймгийн БОАЖГ |
| 2 | Сүмбэр сумын багийн ИНХ | БОМТ-ий тайлан хүргүүлэх | БОМТ-ий биелэлт | 3-р улиралд | 50.0 | Захирал | Сүмбэр сумын багийн ИНХ |
| **Нийт** | | | | | **100.0** | | |

2024 онд хэрэгжүүлсэн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг Говьсүмбэр аймгийн БОАЖГ-т дүгнүүлэхээр хүргүүлээд байна.

# ДҮГНЭЛТ

**Хүснэгт 8. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын гүйцэтгэл**

| № | Зардлын ангилал | Төсөв, мян.төг |
|---|---|---|
| **1.** | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 18076.0 |
| **2.** | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө | 5500.0 |
| **3.** | Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | - |
| **4.** | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 1480.0 |
| **5.** | Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр | 150.0 |
| **6.** | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | 1000.0 |
| **7.** | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө | 100.0 |
| **Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт төсөв, мян.төг** | | **26306.0** |

“Эф Би Эл Жи” ХХК-ийн Гаалийн хяналтын талбайн 2024 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэд нийт **26306.0 мянган төгрөг** зарцуулсан байна.

БАТЛАВ:
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ Г. ЭНХМӨНХ

ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Ө. МӨНХБАЯР

# "ЭФ БИ ЭЛ ЖИ" ХХК-НИЙ "ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ" ТӨСӨЛ -ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

